

ОРШИЛ

Саяхныг хүртэл Монголын бичил санхүүгийн үйлчилгээ Засгийн газар болон донор байгууллагуудаас хязгаарлагдмал хүрээнд хэрэгжүүлж ирсэн төсөл, арга хэмжээгээр хязгаарлагдаж байлаа. Бичил санхүүг тодорхой хугацаанд хэрэгжиж дуусах төсөл гэдэг утгаар хүлээн авч ханддаг байсан бөгөөд төслийн зорилго нь эргэн төлөгдөх нөхцлөөр маш бага хүүтэй, эсвэл хүүгүй зээл олгоход чиглэж байв. "Байгууллагын тогтвортой хөгжил", "харилцагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ" болон "санхүүгийн сахилга батын соёл" зэрэг нэр томъёонууд монгол хэлний үгсийн санд бараг хэрэглэгддэггүй байв. Гэсэн хэдий ч 1998 оноос хойш бичил санхүү нь Монголд ядуурлыг бууруулах, хөрөнгөтэй болох, орлого нэмэгдүүлэх хүчтэй арга хэрэгсэл болон хөгжиж үндэсний хэмжээнд төдийгүй олон улсын түвшинд гайхагдахаар амжилтад хүрчээ.

Монголын өнөөгийн нөхцөлд бичил санхүүг Мянганы Хөгжлийн Зорилтуудыг биелүүлэх үндэсний чадварын чухал бүрэлдэхүүн хэсэг хэмээн үзэж байна. Өнөөдөр бичил бизнес эрхлэгчид болон орлого багатай иргэд хот хөдөөгүй бичил санхүүгийн дэд салбарын үндсэн үйлчлүүлэгчид болж харилцагчдын дийлэнх хувийг эзэлж байна. Энэ нь олон улсын харьцуулалтаар гайхагдахуйц ололт амжилт хэмээн зүй ёсоор тооцогдож болохоор байна. Монголын нийт 17 арилжааны банкнаас хоёр банк (ХасБанк ба ХААН Банк) өөрсдийн идэвхтэй үйл ажиллагаагаараа олон улсын түвшинд "мөс хагалагч" санхүүгийн байгууллага хэмээн хүлээн зөвшөөрөгдөх боллоо. Бичил санхүүгийн дэд салбарыг хөгжүүлэх хүчтэй түлхэц болсон хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлсэн гэсэн утгаар Монгол Улсын Засгийн газар бүс нутгийн шилжилтийн эдийн засаг бүхий орнуудын дундаас үлгэрлэх загвар нь болсон юм. Монгол Улс мэдээлэл харилцааны технологи, лизинг, үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн зээл олгох, хөдөө орон нутаг дахь санхүүгийн үйлчилгээ болон институциональ өөрчлөлт шинэчлэл зэрэг чиглэлээрх санхүүгийн шинэчлэлд практик хувь нэмэр оруулах замаар олон улсын "шилдэг туршлага"-д зүй ёсны хувь нэмрээ оруулж байна. Гэсэн хэдий ч жижиглэнгийн түвшинд буюу бичил санхүүгийн үйлчилгээ үзүүлэх түвшинд, таатай орчин бүрдүүлэх тал дээр шийдвэрлэвэл зохих асуудлууд байсаар байна. Тухайлбал, жижиглэнгийн түвшинд ядуу иргэдийн нэн ядуу хэсэгт бичил санхүүгийн үйлчилгээг хүргэх, бичил даатгал (өрхийн болон орлого нэмэгдүүлэх үйл ажиллагааны аль алины хувьд), институциональ засаглал ба ил тод байдал, санхүүгийн лизинг, тэр дундаа санхүүгийн лизингийн үйлчилгээг малчдад хүргэх хүртээмж болон бичил санхүүгийн үйлчилгээ хүртэгч иргэдийн санхүүгийн боловсрол болон эрх ашгийг хамгаалах зэрэг чиглэлээр шийдвэрлэвэл зохих асуудлууд байсаар байна.

Бичил санхүүгийн таатай орчинг бүрдүүлэх тал дээр дараах асуудлыг шийдвэрлэх хэрэгцээтэй байна. Үүнд:

- дэд салбарт төрийн бус байгууллагуудын гүйцэтгэх үүрэг
- хадгаламж зээлийн хоршоодын үйл ажиллагаанд тавих хяналт, зохицуулалт, мөн лизинг, даатгалын шинэ үйлчилгээ нэвтрүүлэх таатай орчин бүрдүүлэхүйц хууль эрх зүйн зохицуулалт

Ядуу амьдралтай болон эмзэг бүлэгт хамаарах иргэдийн хэрэгцээг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд өгсөн зээлээ тайлагнадаг үр нөлөөтэй тогтолцоо байхгүй нөхцөлд болон эдгээр харилцагчдад үйлчилгээ үзүүлж буй санхүүгийн байгууллагуудын тоо эрс нэмэгдэж байгаа нөхцөлд хэдхэн жилийн дотор тухайн дэд салбарт хэт төвлөрөл үүсэх эрсдэл байгаа бөгөөд улмаар нэг бус санхүүгийн байгууллагыг татан буулгах, эргэн төлөгдөхгүй зээлийн хэмжээ өсөх байдалд хүрч болзошгүй.

Өнөөгийн тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх, бичил санхүүгийн дэд салбарын хэт төвлөрлийн эрсдэлийг бууруулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авах, үйл ажиллагааг тууштай дэмжих дээвэр байгууллага болон бүтэц, нэгжүүд удахгүй бий болно хэмээн найдаж байна.

Энэхүү судалгааны ажлын зорилго нь Монгол дахь бичил санхүүгийн салбарын өнөөдрийн хүрсэн түвшинг харуулахын зэрэгцээ шинээр гарч буй боломж, тулгарч болох бэрхшээлүүдийг урьдчилан харж тэдгээрийг дэлгэн харуулах явдал юм. Судалгааны тайланд бичил санхүүг Монгол Улсын санхүүгийн салбарын үндсэн нэг хэсгийнх нь хувьд дэд салбар хэмээн томъёолж оруулсан болно. Судалгааны ажлын гол үр дүнг уг тайлангийн эхний хэсэгт товч өгүүлсний дараа:

1-р бүлэгт, түүнд хэрэглэх агуулгын шинжтэй нэр томъёонуудыг тайлбарлалаа.

2-р бүлэгт, Монгол дахь бичил санхүүгийн үйлчилгээний эрэлт хэрэгцээ, уг бичил санхүүгийн үйлчилгээний гол хэрэглэгчид болон тухайн зах зээл дээр хэрэгцээтэй байгаа үйлчилгээний талаар тусгалаа.

3-р бүлэгт, бичил санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг албан бус сектороос эхлэн арилжааны банкууд хүртэлх санхүүгийн байгууллагуудын талаар ерөнхий ойлголт өгнө.

4-р бүлэгт, ЯОУХАБ-ны 2003 оны тайланд тусгасан "Хөдөө орон нутаг дахь санхүүгийн үйлчилгээг хэрхэн жижиг зээлдэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэх вэ" гэсэн зөвлөмжүүдээс тусгасан болно.

5-р бүлэгт, Засгийн газрын гүйцэтгэх үүрэг болон Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн талаар өгүүлэх болно.

6-р бүлэгт, донор байгууллагууд болон Монголын бичил санхүүгийн дэд салбарт хөрөнгө оруулж буй бусад хөрөнгө оруулагчдын гүйцэтгэж буй үүргийн талаар товч өгүүлэхболно.

7-р болон эцсийн бүлэгт, бичил санхүүгийн болон нийт санхүүгийн салбарын хөгжлийг дэмжин түүнийг бэхжүүлэх чухал үүрэг гүйцэтгэх байгууллагуудын талаар өгүүлэхболно.

Энэхүү тайлан нь Засгийн газар, парламентын гишүүд, донор байгууллагууд, бичил санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд, судлаачид болон шударга эдийн засгийн хөгжлийн явцад санхүүгийн үйлчилгээг улам бүр хөгжүүлэх замаар Монгол орныг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулдаг бусад бүхий л хүмүүст зориулагдсан юм.

Энэхүү тайланг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ), Нийгмийн Хамгаалал Хөдөлмөрийн Яамны захиалгаар бэлтгэсэн болно.

Судалгааны ажилд тусгагдсан санал зөвлөмжүүд нь НҮБХХ болон Монгол Улсын

Засгийн газрын албан ёсны байр суурийг үл илтгэх бөгөөд зөвхөн зохиогчдын санал бодлыг илэрхийлнэ. Судалгааны ажилд алдаатай бичигдсэн болон орхигдуулсан зүйлс нь зөвхөн зохиогчдын хариуцлагатай холбоотой.

СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ

Бичил санхүүгийн үйлчлүүлэгчид

1. Монголын нийт айл өрхийн дийлэнх хэсэг буюу нийт хүн амын 35.6 орчим хувь нь ядуу, нийт хүн амын 35 орчим хувь нь ядуурлын ирмэгт тулж ирчихээд байна гэж үзэж болно. Үүнээс үүдээд онолын хувьд нийт өрхийн 70%-ийг бичил санхүүгийн үйлчилгээний хэрэглэгчид хэмээн тооцож болно.
2. Сүүлийн 6 жилд Монголчууд банкинд мөнгөө хадгалуулах нь эрс нэмэгдсэн хэдий ч хөдөөгийн айл өрхүүд, ядуучууд болон хотын гэр хороололд амьдардаг хүмүүс гол төлөв санхүүгийн албан сектороос гадуур мөнгөө хадгалуулж байна. Нэн ядуу хэсгийнхний хувьд зээл авахаасаа хуримтлал бий болгох нь илүү чухал юм.
3. Бичил бизнес эрхлэгчид болон хөдөөгийн айл өрх,-иргэдийн зээл хүртэх боломж нэмэгдсээр байна. Тухайлбал, 1998 онд нийт айл өрхийн 1% зээл авч байсан бол 2004 оны дунд үед энэ үзүүлэлт 26% болтлоо өсчээ. Гэвч айл өрхүүдийн, ялангуяа гэр хорооллынхон болоод малчид, нэн ядуу өрхүүдийн санхүүгийн хэрэгцээ бүрэн хангагдаагүй байна.
4. Сүүлийн 7 жилд иргэдийн санхүүгийн сахилга бат эрс сайжирсан. Дунд зэргийн орлоготой болон орлого ихтэй бүлгүүдтэй харьцуулбал ядуу болон ядуурлын ирмэгт байгаа бүлгийнхэн авсан зээлээ илүү хариуцлагатайгаар эргэн төлж байна.
5. Эмэгтэйчүүд зээл болон бусад санхүүгийн үйлчилгээ хүртэхэд онц саад тотгор, бэрхшээл байхгүй байна. Эрэгтэйчүүдтэй харьцуулбал санхүүгийн байгууллагуудад эмэгтэйчүүд цөөн тооны удирдлагын дээд түвшний эсвэл удирдах зөвлөлд албан тушаал хашиж байна. Зээлийн эргэн төлөлтийн хувьд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хооронд онцын ялгаа байхгүй байна.
6. Бичил санхүүгийн үйлчилгээний эрэлт хэрэгцээ хадгаламж, зээлээр хязгаарлагдахаа больж даатгал, санхүүгийн лизинг, гуйвуулга, төлбөр тооцоо зэрэг санхүүгийн бусад үйлчилгээг мөн хамрах болсон.
7. Үйлчлүүлэгчийн эрхэлж буй хөдөлмөр эсвэл бизнесийн төрлөөс хамааран санхүүгийн үйлчилгээний эрэлт хэрэгцээний төрөл, нөхцөл өөр хоорондоо нэлээд ялгаатай байна. Малчид, фермерийн аж ахуйтнуудын санхүүгийн үйлчилгээний эрэлт хэрэгцээ бүрэн хангагдаагүй хэвээр байгаагийн зэрэгцээ тэдгээрийн хэрэгцээнд тохирсон санхүүгийн бүтээгдэхүүн зах зээл дээр байхгүй байна.
8. Үйлчлүүлэгчдийн хувьд барьцаат хөрөнгө зээл авахад тулгарч буй хамгийн том саад тотгор байсан хэвээр байна.
9. Иргэд хоршоо, банк бус санхүүгийн байгууллага болон санхүүгийн бусад зуучлагчид гэхээсээ илүү арилжааны банкуудаар дамжуулан өөрсдийн санхүүгийн гүйлгээгээ хийхийг илүүд үзэж байна.

10. Эмпирик судалгаанаас үзэхэд бичил санхүүгийн үйлчилгээг хүртэгчдийн цөөнгүй хэсэг хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтын орчин байдаггүй болон санхүүгийн боловсрол дутмагаасаа үүдэн хохирох явдал гарсаар байна. Мөн үүнээс үүдэн эдгээр үйлчлүүлэгчид их хэмжээний өрөнд унах, барьцаалсан хөрөнгөө алдах, сэтгэл санааны дарамтад орох, бусдад эд хөрөнгөө алдахад хүрч байна. Хэдийгээр эдгээр тохиолдлыг судалж, үнэлгээ дүгнэлт өгөөгүй боловч цаашид энэ байдал өсөж болзошгүй гэж үзэж байна.

Бичил санхүүгийн нийлүүлэлт

1. Сүүлийн 6 жилд Монголд бүртгэгдсэн санхүүгийн байгууллагын тоо, тэр дундаа ББСБ-ууд, ХЗХ-ын тоо эрс нэмэгдсэн. Энэ нь нэг талаар үзүүлж буй санхүүгийн үйлчилгээний чанар, цар хүрээнд сайнаар нөлөөлөх хэдий ч эдгээр үйлчилгээний дийлэнх хэсэг нь хот суурин газарт хэт төвлөрч улмаар зах зээл ханаж, тус салбарт зохиомол хөөрөгдөл бий болох зэрэг сөрөг үр дагавар гарч байна.

2. Санхүүгийн зуучлагч байгууллагуудын тоо ийнхүү хэт өссөн нь тэдгээрийн, ялангуяа зээлийн хоршоод болон ББСБ-уудын үйл ажиллагаанд хяналт тавьж зохицуулахад Төв банкны чадавхи хүрэлцэхгүйд хүргэж болзошгүй байна.

3. Хоёр арилжааны банк, тухайлбал ХААН Банк, ХасБанкинд нийт зээлийн өрийн үлдэгдлийн 75.2% (тоогоор, үнийн дүнгээр бус) ногдож байна гэсэн тооцоо байна. Харин санхүүгийн салбарын нийт активын хэмжээ, зээл болон хадгаламжийн хэмжээ бусад 15 банкинд арай илүү тэгш ногдож байна. Ойролцоогоор 395 "идэвхтэй" ББСБ болон ХЗХ-нд санхүүгийн салбарын нийт активын дөнгөж 7.4% ногдож байна. Үүнээс үүдэн одоогоор үйл ажиллагаагаа явуулж байгаа санхүүгийн зуучлагчдын дийлэнх хувийн үйл ажиллагааг зогсоох, бусад санхүүгийн зуучлагчид худалдан авах, эсвэл нэгтгэх байх гэсэн дүгнэлтэнд хүрч болохоор байна.

4. Одоогоор орлого багатай айл өрхүүдэд үзүүлж буй санхүүгийн үйлчилгээний нэр төрөл, цар хүрээ өргөн байна. Үүнд, хот хөдөөд адил зээл олгох шинэлэг арга механизм, ядуучуудад чиглэсэн хадгаламжийн үйлчилгээ, үйлчлүүлэгчдэд хандсан санхүүгийн лизингийн үйлчилгээ, үр ашигтай гуйвуулга, төлбөр тооцооны арга механизмыг дурдаж болно. Нэн ядуучуудад чиглэсэн санхүүгийн үйлчилгээ нэвтрүүлэх, мэдээллийн технологийг ашиглах, даатгалын төрөл бүрийн арга хэрэгслүүдийг зах зээлд нэвтрүүлэх, бичил бизнес эрхлэгчдэд чиглэсэн санхүүгийн лизингийн үйлчилгээг нэвтрүүлэх зэрэг чиглэлд шинийг эрэлхийлэн ажиллах шаардлага урган гарч байна.

5. Зээлийн өрийн үлдэгдлийн 80.6% нь (үнийн дүнгээр) хүн ам ихтэй Улаанбаатар, Дархан гэсэн хоёр том хотод ногдож байгаа нь 2002 онд 90.2% байснаас ялимгүй буурсан харагдаж байна. Энэ нь хөдөө орон нутагт хүрч үйлчлэх шаардлага байгаагийн тод жишээ юм.

6. ХААН Банк алслагдсан хөдөө орон нутагт санхүүгийн үйлчилгээг зонхилон хүргэж байна. Хоршоодын тоо эрс нэмэгдсэн энэ үед ХасБанк үйл ажиллагаагаа хөдөө орон нутагт өргөжүүлэх гэж байгаатай холбогдон хөдөө орон нутаг дахь өрсөлдөөн ихсэх хандлагатай байна.

7. Бичил санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг санхүүгийн байгууллагууд донорын өчүүхэн дэмжлэгтэйгээр, зарим тохиолдолд (ялангуяа хоршоод болон ББСБ-ууд) тэдгээрийн зүгээс ямар ч дэмжлэг авалгүйгээр үйл ажиллагаагаа өргөжүүлэх чадвартай гэдгээ харуулж чадсан.

8. Хэд хэдэн хотын ХЗХ, ХасБанк, Кредит Монгол, ХААН Банк зэрэг зах зээлийн тэргүүлэгчид институцийн чадавхи, гүйцэтгэлээрээ олон улсын стандарт, шалгуур үзүүлэлттэй нийцэж чадаж байгаагаа харуулсан.

9. Сүүлийн хэдэн жилд ТББ-уудын гүйцэтгэх үүрэг багассан бөгөөд Монгол банк нэг ч ТББ-д санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоогүй байна. Гэвч үүнээс үл хамааран цөөн тооны, ялангуяа олон улсын ТББ-ууд нэн ядуу хэсэгт хүрэх санхүүгийн үйлчилгээг эрэлхийлэхэд тэргүүлэн ажиллаж байна. Бичил санхүүгийн дэд салбарт оролцох ТББ-уудын оролцоо ихсэх хандлагатай байна.

10. Монголд (тухайн байгууллагын төрлөөс хамааран) санхүүгийн салбар болон тэр дундаа бичил санхүүгийн дэд салбарт үйл ажиллагаа явуулдаг дээвэр байгууллагын чадавхи сул (үйл ажиллагаа нь жигдрээгүй, эсвэл ийм байгууллага байхгүй, эсвэл тэдгээрийн үйл ажиллагаа уялдаа холбоогүй) байна. Аудиторын компани, удирдлагын мэдээллийн системээр хангагч байгууллага, зөвлөх компани зэрэг дэмжлэг үзүүлдэг бүтэц, нэгжүүдийн тоо өсөж байна.

Засгийн газрын баримталж буй бодлого

1. Монгол Улсын Засгийн газар бичил санхүүг Мянганы Хөгжлийн Зорилтуудыг биелүүлэх, ядуурлыг бууруулах стратегийг хэрэгжүүлэх, санхүүгийн салбарын тогтолцоог өөрчлөн шинэчлэх болон мөрийн хөтөлбөрөө биелүүлэхэд салшгүй, чухал хэрэгсэл хэмээн үзэж байна. Монгол Улсын Засгийн газар 2005 оныг Монголын Бичил Санхүүгийн Жил болгон зарласан.

2. Монголд санхүүгийн салбарыг хөгжүүлэх ерөнхий орчин нааштай бөгөөд байнга сайжирч байна. Зах зээлийн өрсөлдөөн бий болгох, түүнийг хөхүүлэн дэмжих үүднээс "бичил санхүү"-гийн харилцааг зохицуулсан тусгай хууль эрх зүйн актыг Монгол банкнаас санаачлан батлуулаагүй хэдий ч ашгийн төлөө байгууллагууд энэ салбарт нэлээд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Харин бичил санхүүгийн харилцааг зохицуулсан тусгай хууль эрх зүйн акт байхгүйгээс ТББ-ууд хохирч байна.

3. Хөтөлбөрийн хүрээнд болон төсөл хэрэгжүүлэх нэгжээр дамжуулан шууд зээл олгох зэргээр бичил санхүүгийн дэд салбарт оролцох Засгийн газрын оролцоо эрс багассан. Ингэснээр хувийн хэвшлийн санхүүгийн байгууллагуудын дунд нээлттэй, шударга өрсөлдөөн бий болох нааштай нөхцөл бий болж дамжуулан зээлдүүлэх үйл ажиллагаанд оролцох Засгийн газрын оролцоо хэвээр байгаагийн зэрэгцээ цаашид ч өсөх бололтой. (Жишээ нь, Бичил санхүүгийн хөгжлийн сан)

4. Хадгаламж Зээлийн Хоршоодын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих үүргийг саяхнаас Монгол банк гүйцэтгэхээр болсон. Тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулах тусгай заавар, журам тодорхой бус хэвээр байна.

5. Санхүүгийн зуучлагч байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулахын тулд хэд хэдэн хууль эрх зүйн акт, заавар, журмыг сайжруулах шаардлагатай байна. Тухайлбал, ББСБ-ын зээлийн эрсдэлийн санд татвар ногдуулах, ХЗХ эрхэлж болох үйл ажиллагаа, ТББ-уудын үүрэг, рейтингийн агентлаг бий болгох зэрэг асуудлыг зохицуулах шаардлагатай байна. Эдгээр асуудлыг НҮБХХ, Монгол банкнаас саяхан хамтран хэвлэж гаргасан "Бичил санхүүгийн дэд салбарын хууль эрх зүйн орчинд хийсэн судалгаа"-нд дэлгэрэнгүй авч үзсэн болно¹¹.

Донорууд болон хөрөнгө оруулагчдын гүйцэтгэх үүрэг

1. Монголд бичил санхүүгийн үйлчилгээний өсөлтийг түргэтгэхэд Олон улсын болон ТББ-ууд маш чухал үүрэг гүйцэтгэсэн. Эдгээр байгууллагын ихэнх нь өөрсдийн санхүүжилтээ цаг үеэ өнгөрөөсөн "төсөл"-ийн хэлбэрээр бус харин институцийн чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн олон улсын "шилдэг туршлага"-д нийцсэн арга хэлбэрээр дамжуулан олгосон. Донорын зээлийн хөрөнгийн капиталжуулалт цаашид шаардлагагүй байж болохын зэрэгцээ санхүүгийн зуучлагч байгууллагуудын дотоодын хуримтлалыг татан төвлөрүүлэхэд сөргөөр нөлөөлөх магадлалтай.

2. Бичил санхүүгийн салбарт гүйцэтгэх донорын үүрэг роль 6 жилийн өмнөхтэй харьцуулбал төдийлөн чухал биш болжээ. Ашгийн болон хагас ашгийн төлөө хөрөнгө оруулагчид доноруудын оронд санхүүгийн байгууллагуудыг хөрөнгөжүүлэх үүргийг гүйцэтгэж байна. Өнөөгийн байдлаар Олон улсын бичил санхүүгийн хөрөнгө оруулалтын сангууд, ялангуяа бичил санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг хоёр том байгууллага болох ХААН Банк, ХасБанкаар дамжуулан Монголд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

3. Монголд санхүүгийн болон бичил санхүүгийн дэд салбарт дэмжлэг үзүүлж буй доноруудын үйл ажиллагааг зангидан зохицуулах үүрэг бүхий хороо гэж байхгүй байна. Монголд байгаа донор байгууллагууд бичил санхүүгийн донорын олон улсын стандартын талаар төдийлөн сайн ойлголтгүй байна.

4. Дотоодын хөрөнгө оруулагчид сайн засаглалын зарчим, бичил санхүүгийн нийгэмд гүйцэтгэх үүрэг, ач холбогдлын талаар сайн ойлголтгүй байна. Үүнээс үүдэн урт хугацаанд институцийн хувьд амьдрах чадвартай, ядуучууд руу чиглэсэн тогтвортой үйлчилгээ үзүүлэхээс илүү богино хугацааны ашиг орлогыг урьтал болгосон санхүүгийн байгууллагуудын тоо ихэссэн. Цөөн тооны, чухал, хэд хэдэн хотын санхүүгийн байгууллага ялангуяа хоршоо, арилжааны банкууд бүтцийн өөрчлөлт хийж өөрсдийн засаглалын бүтэц, тогтолцоогоо шинэчилж байна.

5. Доноруудын гүйцэтгэх үүрэг байнга шинэчлэн өөрчлөгдөж, зээлийн хөрөнгийг капиталжуулахаас өөр санхүүжилт шаардаж байна. Тухайлбал, дэмжлэг үзүүлэх бүтэц, нэгжүүдийг (жишээ нь, сургалтын төв, зээлийн товчоо, аудитын компани г.м.) санхүүжүүлэх, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг (жишээ нь, индексжүүлсэн даатгал болон санхүүгийн лизинг) эрэлхийлэхэд тусламж дэмжлэг үзүүлэх, мөн нэн ядуу хэсэгт чиглэсэн санхүүгийн болон бичил санхүүгийн үйлчилгээг хооронд нь уялдуулах (жишээ нь, бизнесийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх болон санхүүгийн боловсрол олгох) зэрэг асуудал багтана.

¹ санхүүгийн дэд салбарын хууль эрх зүйн орчны судалгаа, Монгол банк/НҮБХХ, 2004 он.